



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2004 оны 9 сарын 3 өдөр

Дугаар 304

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

"Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2003 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн болон мөн оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хурлын тэмдэглэлүүд, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2,6-г үндэслэн ТУШААХ НЬ:

1. Төмөр овогтой Самбууням, Доржцоо овогтой Золзаяа нарыг 2004-2005 оны хичээлийн жилээс Англи улсын Лондон хотын Технологи Менежментийн сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар тус тус суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2003 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 235 дугаар тушаалын Т.Самбуунямтай холбогдолтой хэсгийг, мөн оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 438 дугаар тушаалын Д.Золзаяатай холбогдолтой хэсгийг хүчингүй болсонд тус тус тооцсугай.

2003-205 тушаалд кодификаци хийгдэв

2003-438 тушаалд кодификаци хийгдэв

САЙД

*Tsamsumba* А.ЦАНЖИД

